

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори,
Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирлын 2015 оны
А/5 А/7 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

**ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ 3 ДУГААР БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Монгол Улсын хүнс болон эмийн аюулгүй байдлыг хангахад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, эм, уламжлалт эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлсон бодлого, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, баримтад тулгуурлан бий болгоно.

Энэхүү хурал нь дээрх чиглэлээр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн эрдэмтэн, багш, судлаач, шинжээчдийн оролцоо, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тэдний бүтээлийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилготой юм.

Хоёр. Сэдэв

- Хүнс, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний технологи, чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа, шинжилгээ, тулгамдсан асуудлууд;
- Эм, биобэлдмэл, уламжлалт эм, эмнэлгийн хэрэгслийн технологи, чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа, шинжилгээ, тулгамдсан асуудлууд;
- Хүрээлэн буй орчны судалгаа, шинжилгээ

Гурав. Зохион байгуулалтын үе шат

1. Эрдэм шинжилгээний өгүүллийг 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулах комисс хүлээн авна.
2. Шаардлага хангасан эрдэм шинжилгээний өгүүллийг нэгтгэж, 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор эмхэтгэл болгон хэвлүүлнэ.

3. Эрдэм шинжилгээний бага хурлын урилга, хөтөлбөрийг оролцогчдод 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Дөрөв. Эмхтгэлд хэвлүүлэх өгүүлэлд тавигдах шаардлага

Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дараах шаардлагыг хангасан байвал зохино:

1. Өгүүлэл нь МОНГОЛ хэлээр, Microsoft Word программ дээр бичигдсэн байна. Өгүүллийг А4 хэмжээний цаасан дээр хуудасны дээд, доод талаас 3 см; баруун, зүүн талаас 2,5 см зайг үлдээж бичнэ. Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй. Мөн хуудасны дугаарыг тавихгүй. А4 форматаар 4-10 нүүр хүртэл байна. Өгүүллийн үндсэн текстийг Times New Roman фондоор, 12pt, мөрүүд нь баруун зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
2. Эрдэм шинжилгээний өгүүлэл (ЭШӨ) нь дараах хэсгүүдтэй байна.
 - 3.1 Өгүүллийн нэр - Times New Roman фондоор, 14pt, Bold, ТОМ ҮСГЭЭР, мөр голлоно.
 - 3.2 Зохиогчийн нэр, хаяг, электрон шуудангийн хаяг - Times New Roman фондоор, 12pt, мөр голлоно.
 - 3.3 Хураангуй - Times New Roman фондоор 15 мөр 200 үгэнд багтаан бичнэ. Зүйл нь шинэ мөрнөөс, мөрний эхнээс эхлэх ба мөр хоорондын зай 1sp байна. Мөрүүд нь баруун зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
 - 3.4 Түлхүүр үг - Times New Roman фондоор, 12pt-ээр 4-5 түлхүүр үг хэрэглэж бичигдэнэ. Түлхүүр үг нь нэр үг, ганц тоон дээр бичигдэнэ. Өгүүллийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй.
 - 3.5 Оршил - Times New Roman фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэх. Оршил хэсэгт судалгааны мөн чанар, судлагдсан байдал, гол онцлогуудыг бичнэ.
 - 3.6 Үндсэн хэсэг - Times New Roman фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэх, Үүнд: Судалгааны зорилго, зорилт, шинэлэг байдал, ач холбогдол, судалгаанаас гарсан гол үр дүн бичигдэнэ.
 - 3.7 Судалгааны арга зүй - Times New Roman фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэх.

4. Хуралд оролцогчийн мэдүүлэг

- Овог нэр /бүтнээр/;
- Эрдмийн зэрэг, цол;
- Байгууллагын нэр, албан тушаал;
- Харилцах утас, факс;
- E- mail хаяг;
- Илтгэлийн нэр

Тав. Өгүүллийг хүлээн авах хаяг

Өгүүллийг b_ngrl@yahoo.com; m_bayarjrgl@yahoo.com: хаягаар 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл хүлээн авна. Хуралтай холбоотой асуудлаар дээрх хаягаар болон 99255118, 99075616 дугаарын утсаар холбогдоно уу!

Зургаа. Илтгэлийг шалгаруулах шалгуур үзүүлэлтүүд

- Асуудал дэвшүүлж, зорилгодоо хүрсэн байдал;
- Практик ач холбогдолтой;
- Илтгэх болон хэлэлцэх ур чадвар

Долоо. Шалгаруулалт, шагнал

Шалгаруулалт 2015 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 10 цагаас Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн хурлын зааланд явагдах бөгөөд дараахь шагналтай:

- I. Тэргүүн байр - 1: Өргөмжлөл, 400,000 төгрөг;
- II. Дэд байр - 1: Өргөмжлөл, 200,000 төгрөг;
- III. Тусгай байр - 1: Өргөмжлөл, 100,000 төгрөг;

Зохион байгуулах комисс

2015 он

- 3.8 Үр дүн, хэлэлцүүлэг - Times New Roman фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэх,
- 3.9 Хүснэгт болон зураг нь өгүүлэлд орсон дарааллаараа дугаарлагдана. Хүснэгт болон зургийн гарчиг нь Times New Roman фондоор, 12pt, italic хэлбэрээр мөр голлон (хүснэгт 1..., Зураг 1... гэх мэт) бичигдэнэ. Бүх математик бичлэгүүд MS Equation, MathType, LaTeX программаар бичигдэх бөгөөд ердийн математик бичиглэл 12 pt өндөртэй байна. Томъёо нь дээд, доод талаасаа 12 pt зайтай байх ба мөр голлон бичигдэнэ. Томъёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага (1) хаалтанд бичнэ.
- 3.10 Зургийг JPG форматаар, диаграмыг Microsoft Excel програм дээр үйлдэнэ. Фото зураг, зураг, хүснэгт нь зөвхөн хар, цагаан өнгөтэй байна. Scanner ашиглаж оруулсан бүдүүвч зураг болон фото зураг нь 300-400 dpi-аас багагүй нягтралшилтайгаар зургийн *.JPEG өргөтгөлтэйгээр буулгагдаж текстэн дотор мөр голлон байрласан байна. Зураг дээрх үсэг, тооны өндөр нь ерөнхий текстийн үсэгний өндөртэй тэнцүү байна.
- 3.11 Дүгнэлт - Times New Roman фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэх. Өгүүллийн дүгнэлтийг Times New Roman фондоор, 12pt, мөрүүд нь баруун зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 3.12 Ишлэл татсан ном, зохиолын нэрс - Times New Roman фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэх. Өгүүллийн төгсгөлд ишлэл татсан ном, сэтгүүл, зохиолын нэрс, вэб хаягийг бичих бөгөөд өгүүлэлд иш татсан дарааллаар дугаарлана. Нэрсийг Times New Roman фондоор, 12pt үсгийн өндөртэйгээр дараах хэлбэрээр бичнэ. Хэрэв 3-аас дээш хүний нэр орсон хамтын бүтээлээс ишлэл татсан бол эхний 3 хүний нэрсийг бичнэ. Ном зүйн зүүлтийг [...] хаалтанд хийнэ. Жишээ нь: [1].

Жич: Эмхтгэлд орох материал нь шаардлага хангаагүй өгүүллийг буцаах, зохих хэмжээнд засварлаж болох талтай. Өгүүллийг шаардлагын дагуу бичиж, агуулга, найруулга, үг үсгийн алдаанд анхаарч хянуур нямбай хандахыг хүсье!

